



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

᠒᠐᠒᠑ онь ᠕ сарын ᠕ өдөр

Дугаар А/᠑᠐᠘

Улаанбаатар хот

### Нийслэлийн хүүхдийн 242 дугаар цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.7 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалаар байгуулагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 5,932,645.00 (таван сая есөн зуун гучин хоёр мянга зургаан зуун дөчин тав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн хүүхдийн 242 дугаар цэцэрлэг (Я.Мөнхтуяа)-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 14 нэр төрлийн нийт 5,932,645.00 (таван сая есөн зуун гучин хоёр мянга зургаан зуун дөчин тав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүлээлгэн өгөхийг Нийслэлийн хүүхдийн 242 дугаар цэцэрлэг (Я.Мөнхтуяа)-т, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА *В. Оюунмаа* В.ОЮУМАА





Нийслэлийн Өмчийн харилцааны газрын  
 2025 оны 11 дүгээр сарын 11-ны  
 өдрийн АБС дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн 242 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн хурлын дүгнэлт	Байгууллагын үнийн санал	НӨХТ-ийн мэргэжлтийн үнийн санал	ҮХХХК-ийн хурлын шийдвэр
1	Цаг бүртгэлийн систем	8	ш	1	425,000.00	425,000.00	425,000.00	0.00	Ажлын шаардлага хангахгүй	актлах	актлах	татах	татах
2	Зөөврийн компьютер /ASUS X515/	8	ш	1	1,890,300.00	1,890,300.00	1,890,300.00	0.00	Ажлын шаардлага хангахгүй	актлах	актлах	татах	татах
3	4 Ширэмтэй пийшин	8	ш	1	1,250,000.00	1,250,000.00	1,249,999.92	0.08	Ажлын шаардлага хангахгүй	актлах	актлах	татах	татах
4	Хөргөгч /340л/	8	ш	1	332,250.00	332,250.00	332,250.00	0.00	Ажлын шаардлага хангахгүй	актлах	актлах	татах	татах
5	Буузын жигнүүр	8	ш	1	286,650.00	286,650.00	286,650.00	0.00	Ажлын шаардлага хангахгүй	актлах	актлах	татах	татах
6	Тоос сорогч samsung	8	ш	1	84,995.00	84,995.00	84,994.92	0.08	Ажлын шаардлага хангахгүй	актлах	актлах	татах	татах
7	Тоос сорогч dirt divel	8	ш	1	124,500.00	124,500.00	124,500.00	0.00	Ажлын шаардлага хангахгүй	актлах	актлах	татах	татах
8	Тоос сорогч Tornado	8	ш	1	114,950.00	114,950.00	114,950.00	0.00	Ажлын шаардлага хангахгүй	актлах	актлах	татах	татах
9	Хөгжим boss	8	ш	2	90,000.00	180,000.00	180,000.00	0.00	Ажлын шаардлага хангахгүй	актлах	актлах	татах	татах
10	Угаалгын машин media	8	ш	1	125,000.00	125,000.00	124,999.92	0.08	Ажлын шаардлага хангахгүй	актлах	актлах	татах	татах
11	Будаа агшаагч хятад	8	ш	1	119,000.00	119,000.00	119,000.00	0.00	Ажлын шаардлага хангахгүй	актлах	актлах	татах	татах
12	Зөөврийн компьютер /ASER/	8	ш	1	600,000.00	600,000.00	600,000.00	0.00	Ажлын шаардлага хангахгүй	актлах	актлах	татах	татах

